БАТЛАВ:
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ц.ГАНСҮХ
2026 ОНЫ ... ДУГААР САРЫН ... НЫ ӨДӨР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЛТ СУМЫН ТӨВИЙН 3,5 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2026.01.20 Дугаар ЗД-2026/09 Мөрөн сум

1	Зураг, төсөв зохиох үндэслэл	• Хөвсгөл аймгийн "Хөгжсөн Хөвсгөл" 2016-2030 он хөтөлбөр • Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр • Хөвсгөл аймгийн Галт сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
2	Байршил (чиглэл)	Хөвсгөл аймгийн Галт сумын төвийн 3,5 км хатуу хучилттай авто замын ажил.
3	Авто зам, гүүрний техникийн зэрэглэл, урт, овор хэмжээ, хүчин чадал	Галт сумын төвийн 3,5 км хатуу /асфальтан/ хучилттай авто замын ажил. **Авто зам**: • Хатуу хучилттай авто зам /асфальтан/-ыг авто замын норм стандартын дагуу төлөвлөх. Трасс сонголтыг хэмжилтээр тодорхойлох. **Төмөрбетон гүүр:** • Авто замын төвөгшил, үерийн усыг тооцоолж шаардлагатай хэсэгт төмөр бетон гүүрийг тооцоогоор төлөвлөх. **Явган хүний зам талбай:** • Явган хүний зам, талбайн төлөвлөлт" MNS 6808:2019 стандартын шаардлага хангасан явган хүний замыг төлөвлөх. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих тэмдэг, тэмдэглэгээг төлөвлөх. **Ус зайлуулах систем:** • Авто зогсоолын бороо, цасны ус зайлуулах шугам төлөвлөж өгөх. • Ус зайлуулах шугам нь эхлэл төгсгөл дээрээ хог шүүх шүүлтүүртэй байх. Авто зам, талбайн борооны ус зайлуулах шийдэл, Ус зайлуулах симтемийг норм стандартын дагуу төлөвлөх. **Гэрэлтүүлэг:** • Авто зам, явган хүний замын стандартын шаардлага хангасан 200вт-аас багагүй хүчин чадалтай орчин үеийн дэвшилтэд технологи бүхий загварын гэрэлтүүлгийн сонгох Трасс сонголтын үеийн болон замын төлөвлөлтийн төвөгшлийг БНбД-ээс харах

4	Авто зам, гүүрийн барилгын бүрэлдэхүүн, хүчин чадал, урт.	**Авто зам:** Авто зам хийгдэх талбайн суурь судалгаанд үндэслэн авто замын зузаан, суурин тооцоог хийх. Авто замаас 3м-ээс багагүй хөвөөтэй байх. **Ус зайлуулах шугам:** авто замын бороо, цасны ус зайлуулах шугам төлөвлөж өгөх. Ногоон байгууламж руу шингээх байдлаар төлөвлөх. **Гэрэлтүүлэг:** Авто зам, явган хүний замын стандартын шаардлага хангасан 200вт-аас багагүй хүчин чадалтай лед гэрэлтүүлэг төлөвлөх. **Стандартууд:** Авто зам төсөллөх БНбД22-004-2016 Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНбД 32-02-11 Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН 2.01.01-2004 Газар хөдлөлтийн бүс нутаг барилга төлөвлөх БНбД 22.01.01*/2006 Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл БНбД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, Геодезийн ажил БНбД 3.01.03-88 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS4597:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS4596:2014
5	Гүүр ба хоолойн бүтээц	Замын байгууламжид хэрэглэгдэх материалууд Монгол улсын стандартаар батлагдсан тухайн цаг уурын нөхцөлд хэрэглэх шаардлагыг хангасан байхаар тохирлын гэрчилгээ бүхий сайн чанарын материалаар хийхээр төлөвлөсөн байх ба Авто замын гүүр ба хоолой БНбД 32-02-03 стандартын дагуу төлөвлөх
6	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	• Барилгын ажлын зураг нэг үе шаттай байна. • Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
7	Зураг төслийн иж бүрдэл	<u>Зургийн төслийн иж бүрдэл</u> • Ажлын зураг /батлагдсан/ • Авто замын төсөв /батлагдсан/ • Авто замын ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл • Магадлал хийгдсэн зураг төсвийг эх хувь 1, хуулбар хувь 1 тус бүр ирүүлнэ. • Тайлбар бичиг/ хучилтын тооцоо, ус зүйн тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, авто замын зураг төслийн бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөл г.м/ <u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u> Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөнө

8	Зураг төслийн байгууллага:	"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" Монгол улсын хуулийн дагуу тендерээр сонгон шалгаруулна. Зам гүүрний байгууламжийн зураг төсвийн тусгай зөвшөөрөл бүхий ААНэгж
9	Онцгой нөхцөл:	Онцгой нөхцөл • Авто замын зургийг Монгол улсад мөрдөгдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, Явган хүний зам, талбайн төлөвлөлт" MNS 6808:2019, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 0888-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан " Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх. • Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг зурагт тусгах. • Авто зам, замын байгууламжийн техникийн зураг төсөлд замын байгуулалт, зай хэмжээ, хөдөлгөөн зохион байгуулалтыг төсөллөж, цэгүүдийн координат, зам барилгын ажлын тоо хэмжээг оруулсан байна. • Авто замын төвөгшлийг тооцож шаардлагатай нөхцөлд замын төсөвт тусган өгөх • Зам барилгын ажлын гүйцэтгэгч нь холбогдох шугам сүлжээний байгууллагаас тодруулага авах • Тухайн замын үндсэн элементүүдийг (авто зам, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглэгээг) layer тус бүрээр нь салгаж Autocad файлаар өгөх. • Авто замын трасс болон хэмжилтийг газар дээр нь очиж хэмжилт хийж Галт сумын ЗДТГ, Аймгийн ЗДТГ, Аймгийн ГХБХБГазартай зөвшилцөх. • Авто зам барих байршлуудын орчмын өнөөгийн нөхцөлийн судалгааг хийх /Тулгамдаж байгаа асуудлууд, тухайн орчинд одоо байгаа авто замуудын даац, хүн амын нягтрал хэрэгцээг тодорхойлох • Авто замын төвөгшлөөс хамааруулан төмөрбетон гүүрийг төлөвлөх. Төсөвт тусгаж өгөх Авто зогсоолын зураг төсвийг эх хувь 1ш, хуулбар хувь 1ш, цахим хэлбэрээр /DWG,PDF/ хүлээлгэн өгнө.

10	Эдийн засгийн тооцоо (төсөв)	БНбД 81-95-12 төсөв зохиох дүрмийн дагуу төсвийн ESTIMATOR-PRO программ болон түүнтэй ижил эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцно.

ХЯНАСАН:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА: /Э.АЗЗАЯА/

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА: /Д.НЯМБАТ/

ЗУРГИЙН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН: /Д.САНДАГДОРЖ/

Untitled Map
Write a description for your map.
Legend
Galt
Untitled Path
ЗДТГ-ын хойд талын зам
төв зам
Хойд талын хөндлөн зам
Хэмжээ
Эмнэлгийн урдуурх босоо
Galt
Galt
1.1км
IDER
550м
350м
1.5км
Galt - Shine Ider Rd
Google Earth
Image © 2026 Airbus
600 m